



**МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 1А-039

Улаанбаатар хот

**Инкубатор компанийг хугацаанаас
өмнө төгсгөх тухай**

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.11 дэх заалтууд, “Мэдээллийн, технологийн инкубаторын үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.5 дахь заалт, 2021 оны 8 сарын 30-ны №01/24 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологийн инкубаторын 35 дахь сонгон шалгаруулалтаар элсэн орсон иргэн “Ай Кэй Си Эм” ХХК нь хугацаанаасаа өмнө төгсөх хүсэлт гаргасан тул зохих журмын дагуу инкубаторыг төгсгөн гаргахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. “Ай Кэй Си Эм” ХХК нь төгсөлтийн үнэлгээгээр 76.4% авсан тул хамтран ажиллах гэрээг дуусгавар болгох, барьцаа төлбөрийг буцаан олгохыг нягтлан бодогч /Д.Цэрэндолгор/, эд хөрөнгө, өрөө танхим хүлээн авахыг нярав /Ж.Уянга/, стартап менежер /Б.Долгион/ нарт тус тус даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төслийн удирдлага, сургалт, маркетингийн хэлтсийн дарга /П.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Э.ЦОГТГЭРЭЛ